

БАТЛАВ:

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН

Э.БАТШУГАР

**ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага.

1.1.Хууль зүйн үндэслэл.

Зээлийн мэдээллийн тухай хуулийг 2011 оны 10 дугаар сарын 20-ны өдөр баталж баталснаас хойш нэмэлт болон нэмэлт, өөрчлөлтийг нийт дөрвөн удаа оруулсан болно. “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай Монгол Улсын Их Хурлын 2020 оны 5 дугаар сарын 13-ний 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын “Ухаалах санхүүгийн зах зээл” үндэсний нэгдмэл үнэт зүйлийн 4.3-т “олон олон улсын санхүүгийн зах зээлтэй холбогдсон олон тулгуурт, хүртээмжтэй санхүүгийн системийг хөгжүүлнэ”, 4.3.5-д “банк санхүүгийн зах зээлийн эрсдэл даах, найдвартай байдал хангагдана” гэж тус тус заасан. Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай Монгол Улсын Их Хурлын 2020 оны 8 дугаар сарын 28-ны 23 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 4.3-т “эдийн засгийг тэтгэсэн, уян хатан, цахим технологид суурилсан олон талт санхүүгийн үйлчилгээг хөгжүүлнэ” гэж заасныг болон Улсын Их Хурлаас баталсан бусад баримт, бичийг үндэслэн банк, санхүүгийн салбарын хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулна.

1.2.Практик шаардлага.

Зээлийн мэдээллийн санд 13 арилжааны банк, 436 банк бус санхүүгийн байгууллага, харилцаа холбооны компаниуд, төрийн яам, агентлагуудын дэргэдэх сангууд, хадгаламж зээлийн хоршоо гэх мэтчилэн төрийн, хувийн хэвшлийн байгууллагууд иргэн, аж ахуй нэгжийн зээл, төлбөрийн үүргийн талаарх мэдээллийг нийлүүлдэг бөгөөд 2024 оны 2 дугаар сарын байдлаар 1.6 сая иргэн, 19.6 мянган аж ахуйн нэгжийн зээлийн мэдээлэл хадгалагдаж байна.

Банкны салбарын нийт актив хөрөнгийн хэмжээ 2024 оны 1 дүгээр сарын байдлаар 54.2 их наяд төгрөгт хүрсэн бол мөн хугацаанд арилжааны банкны өөрийн хөрөнгийн хэмжээ 5.8 их наяд төгрөг болж нэмэгдсэн байна. Арилжааны банкны өөрийн хөрөнгийн хэмжээ 2011 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 0.7 их наяд төгрөг байсан бол банкны салбарын үйл ажиллагаа өргөжиж, ашигт ажиллагаа нэмэгдэн нээлттэй компанийн хэлбэрт шилжсэнээр өөрийн хөрөнгө 8.3 дахин нэмэгдсэн.

Дундаж давхаргыг бэхжүүлсэн нийгэм, эдийн засгийн орчныг бий болгож дундаж давхаргыг тэлэхэд чиглэсэн өрх, гэр бүлд хүртээмжтэй банк, санхүүгийн үйлчилгээ бүтээгдэхүүнээр ханган, эрсдэлээс хамгаалах бодлого хэрэгжиж, өрх, гэр бүл өөрийгөө тэтгэн амьдрах нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай байна. Монгол Улсын хүн амын тоо 2035 онд 4.02 сая хүрэх төсөөлөлтэй байгаа бол насны бүлгээр ангилбал өсөлтүүд голцуу зээлийн харилцаанд орох насны бүлэгт

хамаарч байгаа тул цаашид банк, санхүүгийн үйл ажиллагаа цахим руу шилжих, их өгөгдөл буюу зээлдэгчийн зээлийн мэдээлэл дээр суурилсан шийдвэрийг гаргах шаардлагатайг илтгэж байна.

Зээлийн үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлээс сэргийлэх хамгийн гол арга нь зээлийг анх олгохдоо хийх судалгаа, шинжилгээний чанарыг сайжруулах, судалгаанд шаардлагатай үнэн зөв, бодит мэдээллийг цаг тухайд нь олж, зөв үнэлэх явдал юм. Иймээс зээлдэгчийн зээлийн түүхийн мэдээлэл үнэн зөв байж, зээлийн үнэлгээ, зэрэглэл хийхэд шаардагдах бүх мэдээллийг бүрэн хэмжээгээр агуулсан, мэдээлэл тогтмол шинэчлэгдэж, цаг үеийн мэдээллээр баяжигдаж түүн дээр суурилсан зээлдэгчийн үнэлгээ, зэрэглэл тогтоох аргачлалыг баталсан нэгдсэн журмыг эрх бүхий бодлого тодорхойлогч байгууллага болох Монголбанк батлах шаардлагатай. Зээлийн мэдээллийн тухай хуулиар зээлийн мэдээллийг үйлчилгээ үзүүлэх этгээдийн эрхлэх үйл ажиллагаанд зээлдэгчийн зээлжих чадварт зэрэглэл тогтоох гэж заасан боловч хэрхэн, ямар аргачлалаар зэрэглэл тогтоох талаар зохицуулалтгүй байна. Эрх бүхий бодлого тодорхойлогч байгууллагаар нэгдсэн аргачлал, журам баталснаар зээлийн мэдээллийн санд нийлүүлэгдэж буй мэдээллийг зөв ашиглах, бодит байдалтай нийцсэн, нэгдсэн аргачлалаар зээлдэгчийн зэрэглэлийг тогтоох боломжтой болно.

Зээлдэгчийн хувийн болон өмнөх зээлийн үүрэгтэй холбоотой бодит мэдээлэл нь зээлдүүлэгчийн гаргах зээлийн шийдвэр, зээл эргэн төлөгдөх найдвартай баталгааг хангаж байх учиртай. Энэ хугацаанд зээлийн мэдээллийн сангийн хэвийн үйл ажиллагааг хангах, мэдээллийг нь баяжуулах чиглэлээр Монголбанкнаас арга хэмжээ авч хэрэгжүүлсээр ирсэн бөгөөд ялангуяа программ хангамж, тоног төхөөрөмжийг сайжруулах тодорхой төслүүдийг хэрэгжүүлж ирсэн. Зээлдэгчийн зээлийн мэдээллийг зөв, бодит байдалтай нийцүүлэн ашигласнаар банк, санхүүгийн үйл ажиллагаанд оролцогч талуудын санхүүгийн сахилгыг дээшлүүлэх нөхцөлийг бүрдүүлж шийдвэр гаргалтыг тоон мэдээлэл, тодорхой арга, аргачлалыг үндэслэн хэрэгжүүлэх боломжтой болох юм.

Зээлдэгчийн зээлийн мэдээллийг зээлийн лавлагаанд зургаан жилээр тусгах зохицуулалтыг уян хатан болгож тухайн зээлдэгчийн онцлог, нөхцөл байдалтай нь уялдсан хугацааг олон улсын жишгийн дагуу нийцүүлэх зохицуулалтыг бүрдүүлнэ.

Зээлийн мэдээллийн тухай хуулийн зохицуулалтыг илүү боловсронгуй, зохицуулалт дутагдаж байгаа харилцааг тодорхой болгох замаар зээлдэгчийн зээлжих зэрэглэлийг тогтоох аргачлалыг эрх бүхий бодлого тодорхойлогч байгууллагаар батлуулах нь банк, санхүүгийн салбарын дунд, урт хугацааны хөгжлийг түргэтгэх нөхцөл бүрдэхээр байна.

Дээрх үндэслэл, шаардлагын дагуу иргэн, аж ахуйн нэгж байгууллагын банк, санхүүгийн байгууллага, бусдаас авсан зээлийн түүхийн мэдээллийн бааз сүлжээ, эрх бүхий бодлого тодорхойлогч байгууллагаас нэгдсэн зээлдэгчийн зээлжих чадварт зэрэглэл тогтоох нөхцөлийг бүрдүүлэх, зээлдэгчийн зээлийн мэдээллийг зээлийн лавлагаанд хадгалах хугацааг уян хатан болгох зорилгоор хуулийн төслийг боловсруулна.

Хоёр.Зээлийн мэдээллийн тухайн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн зорилго, бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төслөөр зээлийн мэдээллийг хуульд зааснаас бусад тохиолдолд ашиглахыг хориглон. Зээлдэгчийн зээлийн мэдээллийг зээлийн лавлагаанд тусгах хугацаг уян хатан болгон зээлдэгчийн мэдээллийг зээлдэгчийн зээлжих чадварт зэрэглэл тогтоох аргачлалд ашиглаж, эрх бүхий бодлого тодорхойлогч байгууллагаас зээлдэгчийн зээлжих чадварт зэрэглэл тогтоох аргачлалыг батлуулах зохицуулалтыг тусгана.

Гурав.Зээлийн мэдээллийн тухайн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар үүсэж болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Хуулийн төсөл батлагдсанаар зээлдэгчийн зээлийн мэдээллийг ашиглан эрх бүхий бодлогын байгууллагаас зээлдэгчийн зээлжих зэрэглэлийг тогтоох нэгдсэн аргачлалтай болох бөгөөд банк, санхүүгийн салбарын үйлчилгээ, бүтээгдэхүүнийг төрөлжүүлж, салбарын тогтвортой хөгжил, хүртээмжийг нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.

Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, түүнийг хэрэгжүүлэх зорилгоор цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болох хуулийн талаарх санал

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын гэрээ конвенц болон бусад хууль тогтоомжтой нийцсэн болно. Хуулийн төсөлтэй холбогдуулан аливаа хуульд нэмэлт, өөрчлөлт орохгүй, дагалдах хууль батлахгүй болно. Хуулийн төсөл батлагдахтай холбогдуулж Улсын Их Хурлын тогтоолын төсөл боловсруулна.

ТӨСӨЛ САНААЧЛАГЧ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

20.. оны ... дугаар
сарынны өдөр

Улаанбаатар хот

ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дугаар зүйл.Зээлийн мэдээллийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг нэмсүгэй:

1/10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсэг:

“10.3.Энэ хуулийн 10.1, 10.2-т зааснаас өөр зорилгоор зээлийн мэдээллийг ашиглахыг хориглоно.”

2/14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсэг:

“14.3.Энэ хуулийн 14.1.3-т заасан зээлдэгчийн зээлжих чадварын зэрэглэлийн оноог Монголбанкнаас баталсан аргачлалын дагуу тогтооно.

2 дугаар зүйл.Зээлийн мэдээллийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“10.2.Зээлийн мэдээллийг зээлдэгчийн зээлжих чадварт зэрэглэл тогтооход ашиглана.”

3 дугаар зүйл.Зээлийн мэдээллийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийг “зургаан” гэснийг “зургаа хүртэлх” гэж өөрчилсүгэй.

Гарын үсэг

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

20.. оны ... дугаар
сарынны өдөр

Улаанбаатар хот

Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг баталсантай холбогдуулан захиргааны төв байгууллага болон төрийн байгууллагуудын дэргэдэх сан, Монгол Улсын Хөгжлийн банкнаас зээл, санхүүжилт авсан иргэн, аж ахуйн нэгжийг дараах нөхцөлд хамааруулахгүйгээр зээлдэгчийн зээлжих чадварын зэрэглэлийн оноо тогтоох аргачлал батлахыг Монголбанк /.../-д даалгасугай.

1/иргэн, хувийн өмчит хуулийн этгээд зээлийн өр, төлбөрөө бүрэн төлсөн, зээлийн эргэн төлөлт нь давагдашгүй хүчин зүйлээс хамаарч ангилалд орсон зээлдэгчийн зээлжих чадварын зэрэглэлийн оноог тогтоох;

2/иргэн, хувийн өмчит хуулийн этгээдийн зээлийн төрөл, зээлийн өр, төлбөрийг бүрэн төлж барагдуулсан хугацаанаас хамаарч зээлдэгчийн зээлжих чадварын зэрэглэлийн оноог тогтоох.

2.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо /.../-нд үүрэг болгосугай.

Гарын үсэг